



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

Улаанбаатар хотын жуулчны мэдээлэл,
сурталчилгааны төвүүдийг үргэлжлүүлэн
ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 24/33 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2025 оны А/53 дугаар захирамж, 2022 оны 155 дугаар захирамжаар батлагдсан Газрын дүрмийн 4.1.13, 7.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Дотоод, гадаадын иргэд, жуулчдад Улаанбаатар хотын аялал жуулчлалын талаарх хэрэгцээт мэдээлэл, зөвлөгөө өгөх жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүдийг үргэлжлүүлэн ажиллуулсугай.

2.Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүдийг үргэлжлүүлэн ажиллуулах төсвийг хавсралтаар баталж шаардагдах 180,048,916 (нэг зуун наян сая дөчин найман мянга есөн зуун арван зургаа) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Агентлаг хариуцсан ахлах нягтлан бодогч (С.Ганчимэг)-д зөвшөөрсүгэй.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Мэдээлэл, сурталчилгааны хэлтэс (Б.Энхцэцэг)-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТҮҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны
өдрийн А/01 дүгээр тушаалын хавсралт

УЛААНБААТАР ХОТЫН ЖУУЛЧНЫ МЭДЭЭЛЭЛ
СУРТАЛЧИЛГААНЫ ТӨВҮҮДИЙГ ҮРГЭЛЖЛҮҮЛЭН АЖИЛЛУУЛАХАД
ШААРДЛАГАТАЙ ТӨСӨВ

Д/д	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5	6
1	Цалингийн зардал	Хүн	12*6	1,800,000	129,600,000
2	Унааны зардал /Хөшгийн хөндийн нисэх онгоцны буудал дахь салбар/	Сар	12*3	400,000	14,400,000
3	Түрээсийн зардал /Хөшгийн хөндийн нисэх онгоцны буудал дахь салбар/	Сар	12	1,550,319	18,603,826
4	Бичиг хэргийн зардал	Сар	12	100,000	1,120,000
5	Урсгал зардал /техник тоног төхөөрөмж, мэдээллийн төвүүдийн засвар үйлчилгээ/	Сар	12	350,000	4,200,000
6	Урсгал зардал /цахилгаан, ус, халаалт/	Сар	12	300,000	3,600,000
7	Интернэт үйлчилгээний зардал /Д.Сүхбаатарын Талбай/ Старлинк	Сар	12	210,000	2,520,000
8	Интернэт үйлчилгээний зардал /Хөшгийн хөндийн нисэх онгоцны буудал дахь салбар/ Гэр интернэт	Жил	1	660,000	660,000
9	Телефон утасны төлбөр	Сар	12	90,000	1,080,000
10	Жуулчны мэдээллийн төвийн албан хаагчдын нэгдсэн дүрэмт хувцас	Жил/хүн	1*6	250,000	1,500,000
11	Төв шуудан түрээс, ашиглалтын зардал	Сар	12	230,424	2,765,088
НИЙТ					180,048,916

